



НИЙСГЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 06 сарын 30 өдөр

Дугаар А/117.

Улаанбаатар хот

“Баянзүрх дүүргийн 200 дугаар цэцэрлэгийн”
эргэлтийн бус хөрөнгийг данснаас хасах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 4 дүгээр зүйлийн 4.6, 4.8 дахь хэсэг, Нийслэлийн өмчийн харилцааны газрын даргын А/126 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2025 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн 4 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 3,011,152.0 (гурван сая арван нэгэн мянга нэг зуун тавин хоёр) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг агталж, данс бүртгэлээс хасахыг Баянзүрх дүүргийн 200 дугаар цэцэрлэг (Д.Хэрлэнчимэг)-т зөвшөөрсүгэй.
2. Данснаас хасалдаж буй 8 нэр 3,011,152.0 (гурван сая арван нэгэн мянга нэг зуун тавин хоёр) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг Байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор устгалын акт үйлдэн зохих журмын дагуу Баянзүрх дүүргийн 200 дугаар цэцэрлэг (Д.Хэрлэнчимэг)-т үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиглахыг Захиргаа, удирдлагын хэлтэс (Т.Оюунтуул)-т даалгасугай.

ДАРГА



В. ОЮУМАА

